

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/59/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: narantuuld@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Албан шаардлага	
4.3 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ХОНТСА	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав бөг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.14 № 430
талай -ны № -т

ЖАРГАЛАНТ СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.УРАНБИЛЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

0010 0038

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,305,492</u>	<u>25,597,389</u>
33	АВЛАГА	17,822	575,470
335	Бусад авлага	-	575,470
3351	Байгууллагаас авах авлага	-	575,470
35	БАРАА МАТЕРИАЛ	22,287,670	25,021,919
351	Түүхий эд материал	1,588,250	1,323,779
35130	Эм боох материал	1,588,250	1,323,779
354	Хангамжийн материал	20,699,420	23,698,140
35410	Бичиг хэргийн материал	35,000	35,000
35420	Аж ахуйн материал	309,500	309,500
35430	Сэлбэг хэрэгсэл	240,000	240,000
35460	Хүнсний материал	2,626,710	1,145,700
35470	Бусад хангамжийн материал	17,488,210	21,967,940
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>411,761,607</u>	<u>372,366,549</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	411,761,607	372,366,549
392	Биет хөрөнгө	335,886,307	296,605,499
39201	Барилга, байгууламж, орон сууц	376,664,439	376,664,439
39202	Хуримтлагдсан элэгдэл	(63,226,725)	(96,333,131)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,067,498	35,267,498
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,907,254)	(25,793,691)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,768,181	38,768,181
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,223,724)	(34,711,688)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,743,891	2,743,891
393	Биет бус хөрөнгө	75,875,300	75,761,050
39301	Программ хангамж	457,000	457,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(228,500)	(342,750)
39303	Бусад биет бус хөрөнгө	75,646,800	75,646,800
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>434,067,099</u>	<u>397,963,938</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>269,840</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	269,840
413	Өглөг	-	269,840
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	269,840
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>434,067,099</u>	<u>397,694,099</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	434,067,099	397,694,099
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,490,319	254,490,319
51101	Өмч: - төрийн	254,490,319	254,490,319
512	Хуримтлагдсан үр дүн	(222,221,067)	(258,594,067)
51210	Өмнөх үеийн үр дүн	(222,221,067)	(222,221,067)

51220	Тайлант үеийн үр дүн	-	(36,373,000)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	401,797,847	401,797,847
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>434,067,099</u>	<u>397,963,938</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	464,680,700	459,792,682
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,911,500	523,055
120	Нийтлэг татварын бус орлого	22,911,500	523,055
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,911,500	523,055
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,911,500	523,055
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,769,200	459,269,627
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	373,894,000	394,639,900
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373,894,000	394,639,900
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,378,627
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,176,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,202,627
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,875,200	59,251,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,875,200	59,251,100
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	478,333,894	496,165,682
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,333,894	496,165,682
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,961,378	462,594,705
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,046,123	303,690,376
210101	Үндсэн цалин	248,319,539	193,289,638
210102	Нэмэгдэл	43,060,180	94,565,880
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,280,000	2,300,000
210104	Урамшуулал	4,386,404	13,534,858
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,504,777	38,468,383
210201	Тэтгэврийн даатгал	25,476,714	27,310,057
210202	Тэтгэмжийн даатгал	2,997,260	3,031,928
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,397,808	2,425,545
210204	Ажилгүйдлийн даатгал	512,090	517,888
210205	Эрүүл мэндийн даатгал	5,120,904	5,182,964
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,900,279	59,252,254
210301	Гэрэл, цахилгаан	2,480,099	2,042,334
210302	Түлш, халаалт	37,086,000	45,459,700
210303	Цэвэр, бохир ус	10,334,180	11,750,220
2104	Хангамж, бараа материалын зардал	2,552,848	746,800

210401	Бичиг хэрэг	216,400	37,700
210402	Тээвэр, шатахуун	-	54,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	96,778	273,000
210404	Ном, хэвлэл	-	30,300
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,000	351,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,829,170	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	255,500	-
2105	Нормативт зардал	24,505,510	16,514,835
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	738,550	1,293,705
210502	Хоол, хүнс	23,106,960	14,394,030
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	660,000	827,100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,639,300	1,250,000
210604	Урсгал засвар	1,639,300	1,250,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	532,000	497,700
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000	65,700
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000	432,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,280,541	42,174,358
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	961,159	1,579,300
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,319,382	40,595,058
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,372,516	33,570,978
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,618,348
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	3,618,348
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,372,516	29,952,630
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,372,516	29,952,630
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(13,653,194)</u>	<u>(36,373,000)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(13,653,194)</u>	<u>(36,373,000)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,490,319	402,133,169	(208,925,195)	447,698,293
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	335,322	335,322
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,490,319	402,133,169	(208,589,873)	448,033,615
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(335,322)	-	(335,322)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(13,631,194)	(13,631,194)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,490,319	401,797,847	(222,221,067)	434,067,099

D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	254,490,319	401,797,847	(222,221,067)	434,067,099
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,490,319	401,797,847	(222,221,067)	434,067,099
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(36,373,000)	(36,373,000)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,490,319	401,797,847	(258,594,067)	397,694,099

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>441,769,200</u>	<u>459,269,627</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,769,200	459,269,627
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	373,894,000	394,639,900
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373,894,000	394,639,900
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,378,627
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,176,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,202,627
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,875,200	59,251,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,875,200	59,251,100
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>441,769,200</u>	<u>459,269,627</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,769,200	459,269,627
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,396,684	425,698,649
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,293,300	303,672,554
210101	Үндсэн цалин	176,782,156	181,049,138
210102	Нэмэгдэл	96,588,687	99,673,770
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,627,013	2,300,000
210104	Урамшуулал	20,295,444	20,649,646
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,054,488	38,468,383
210201	Тэтгэврийн даатгал	25,202,588	27,531,456
210202	Тэтгэмжийн даатгал	2,963,100	2,950,596
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,370,400	2,360,477
210204	Ажилгүйдлийн даатгал	628,800	734,920
210205	Эрүүл мэндийн даатгал	5,889,600	4,890,934
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,840,279	58,982,414
210301	Гэрэл, цахилгаан	2,480,099	1,772,494
210302	Түлш, халаалт	37,026,000	45,459,700
210303	Цэвэр, бохир ус	10,334,180	11,750,220
2104	Хангамж, бараа материалын зардал	4,778,237	3,362,579
210401	Бичиг хэрэг	529,200	106,200

210402	Тээвэр, шатахуун	-	54,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	211,937	87,200
210404	Ном, хэвлэл	6,000	60,700
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	209,000	760,279
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,822,100	2,293,400
2105	Нормативт зардал	26,503,080	16,582,920
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,064,800	64,000
210502	Хоол, хүнс	23,319,180	12,913,020
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,119,100	3,605,900
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,639,300	1,250,000
210604	Урсгал засвар	1,639,300	1,250,000
2107	Томилолт, зочны зардал	144,000	-
210702	Дотоод албан томилолт	144,000	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	988,000	575,600
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,000	143,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000	432,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,000	2,804,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,000	2,804,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,372,516	33,570,978
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,618,348
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	3,618,348
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,372,516	29,952,630
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,372,516	29,952,630
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,769,200	417,406,685	462,691,000	423,938,370
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,769,200	417,406,685	462,691,000	423,938,370
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,769,200	417,406,685	462,691,000	423,938,370
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,293,300	296,293,300	303,731,100	303,672,554
210101	Үндсэн цалин	177,213,600	176,782,156	185,336,200	181,049,138
210102	Нэмэгдэл	97,003,800	96,588,687	96,510,000	99,673,770
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,211,900	2,627,013	2,211,900	2,300,000
210104	Урамшуулал	19,864,000	20,295,444	19,673,000	20,649,646

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,999,800	37,054,488	41,003,800	38,468,383
210201	Тэтгэврийн даатгал	28,147,900	25,202,588	28,854,500	27,531,456
210202	Тэтгэмжийн даатгал	2,963,100	2,963,100	3,037,300	2,950,596
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,370,400	2,370,400	2,429,900	2,360,477
210204	Ажилгүйдлийн даатгал	592,600	628,800	607,500	734,920
210205	Эрүүл мэндийн даатгал	5,925,800	5,889,600	6,074,600	4,890,934
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,235,900	53,300,279	67,801,100	58,982,414
210301	Гэрэл, цахилгаан	4,363,100	2,480,099	4,363,100	1,772,494
210302	Түлш, халаалт	49,370,800	40,476,000	49,344,700	45,459,700
210303	Цэвэр, бохир ус	12,502,000	10,344,180	14,093,300	11,750,220
2104	Хангамж, бараа материалын зардал	565,200	1,005,437	2,602,300	2,602,300
210401	Бичиг хэрэг	119,500	185,400	106,200	106,200
210402	Тээвэр, шатахуун	61,700	22,000	54,800	54,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	98,100	211,937	87,200	87,200
210404	Ном, хэвлэл	68,300	59,000	60,700	60,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	217,600	432,100	2,293,400	2,293,400
2105	Нормативт зардал	35,150,400	26,737,080	43,812,900	16,582,920
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,432,000	2,298,800	64,000	64,000
210502	Хоол, хүнс	31,732,500	23,319,180	40,143,000	12,913,020
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	985,900	1,119,100	3,605,900	3,605,900
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,639,300	1,639,300	250,000	250,000
210604	Урсгал засвар	1,639,300	1,639,300	250,000	250,000
2107	Томилолт, зочны зардал	123,700	1	110,000	-
210702	Дотоод албан томилолт	123,700	1	110,000	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,600	544,000	575,600	575,600
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600	112,000	143,600	143,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000	432,000	432,000	432,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,186,000	832,800	2,804,200	2,804,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,186,000	832,800	2,804,200	2,804,200
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,769,200	417,406,685	462,691,000	423,938,370
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	373,894,000	349,531,485	394,639,900	364,687,270
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373,894,000	349,531,485	394,639,900	364,687,270
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,875,200	67,875,200	68,051,100	59,251,100
132001	Орон нутгийн төсвөөс	67,875,200	67,875,200	68,051,100	59,251,100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	23	23
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	14	14
620003	Үйлчлэх ажилтан	8	8	8	8
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1	1	1	1
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1	1	1	1
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23	23	23
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15	15	15	15
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,378,627
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,378,627
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,760,279
2104	Хангамж, бараа материалын зардал	760,279
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	760,279
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000
210604	Урсгал засвар	1,000,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,618,348
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,618,348
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,618,348
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,378,627
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,378,627
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,176,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,202,627

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 02 дугаар сарын 09-нөөс 2021 оны 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын 2 дугаар Цэцэрлэг нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” гэсэн зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- *Сургалтын үйл ажиллагааг хүүхдийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай эцэг эх,асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах,*
- *Хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх,*
- *Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд бага насны хүүхдийн ахиц хөгжлийн түвшинг тодорхойлж хүүхэд бүрийг хөгжүүлэх,*
- *Цахим орчинд өөрийн бэлтгэсэн хичээлүүдийг байршуулах туршлагаа түгээн дэлгэрүүлэх,*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас тус байгууллагад 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 459.8 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 6.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36.1 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 25.0 сая төгрөг болж 2.7 сая төгрөгөөр өссөн нь хүүхдийн зөөлөн эдлэлийг 2.8 сая төгрөгөөр шинэчилсэн холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 21.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 0.5 сая төгрөгөөр нийт 21.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 19.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын данс оны эцэст 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 528.3 сая төгрөг байсан бол оны эцэст 529.5 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд 1.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр хөрөнгө хүлээн аваагүй, акталж устгасан хөрөнгөгүй ба тайлант оны эцэст 372.4 сая төгрөгийн цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст 0.3 сая төгрөгийн гэрэл цахилгааны өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 434.1 сая төгрөг байсан оны эцэст 397.7 сая төгрөг болж тайлант онд 36.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 258.6 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 595.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 595.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд аймгийн ТЕЗ-аас тус байгууллагын төсвийг 495.5 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 495.5 сая төгрөгийн төсөв баталснаас 427.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 68.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 394.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 59.3 сая төгрөг нийт 453.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 423.9 сая төгрөгийг зарцуулж 29.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 423.9 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2.5 сая төгрөгөөр, нормативт зардлыг 27.2 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар аймгийн БСУГ-аас ариутгалын зардалд 0.8 сая, өвөлжилтийн бэлтгэл хангахад 1.0 сая, ХОНТСА-ны тэтгэмжид 3.6 сая бүгд 5.4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 142 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл, 1 мэдээллийг хугацаа хоцроосон мэдээлсэн, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбарыг бичээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 28, зарлагын 7 ажил гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.7 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж, 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 32.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 32.3 сая төгрөгийн алдааг залруулж, 2 алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлбөрийг бүрэн шилжүүлж, уг материалаа хүлээн аваагүй, орлогын баримт үйлдэн 0.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлээр тусгасан,
2. Авлага 0.5 сая төгрөгөөр дутуу тусгасан,
3. Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1.2 сая төгрөгийн хөрөнгийг БҮТЭЗ-д тусгасан,
4. Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн мөнгөөр тохируулах бичилт хийгээгүй 29.9 сая төгрөг,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 32.3 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дугаар сарын 14-ны 6 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.2.1 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг цахим сайтад мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг байршуулахдаа байгууллагын дарга, нягтлан бодогчийн нарын үсэггүй, е-тайлангаас татаж мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын заалтын дагуу холбогдох мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль хууль, журамд заасны дагуу мэдээллийг үнэн зөв мэдээлж хэвших

4.2.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргаагүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг хэмнэлттэй зарцуулах талаар анхааран ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын 2 дугаар Цэцэрлэгийн	6	32.3	4	32.3			-	-	2	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

АХЛАХ АУДИТОР:

Д.НАРАНТУУЛ

